



**ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1758

Улаанбаатар хот

Гадаад сургалтад хамруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 5.37, 5.41, 5.42, 5.43 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Агаарын навигацийн үйлчилгээний газрын Агаарын навигацийн бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн хэлтсийн холбоо, навигаци, ажиглалт хариуцсан мэргэжилтэн Б.Цэнд-Аюуш, Холбоо, навигаци, ажиглалтын албаны Аюулгүй ажиллагаа, чанарын удирдлагын хэсгийн чанар аюулгүй ажиллагааны ахлах технологич инженер М.Отгонжаргал, Техникийн төлөвлөлт, инженерингийн хэсгийн технологич инженер Б.Ернар, Холбооны хэсгийн радио холбооны тасгийн ахлах инженер Д.Оюунболд, Радио холбооны тасгийн ахлах инженер Б.Төмөрбаатар, О.Төрболд, Л.Болд-Эрдэнэ, тус хэсгийн радио холбооны инженер Ж.Болорчимэг, Ц.Заяабаяр, Б.Батзориг, Б.Балган нарыг Бүгд Найрамдах Австри Улсад 2022 оны 3 дугаар сарын 26-ны өдрөөс 4 дүгээр сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулагдах Иргэний нисэхийн үндэсний Төв, Австри Улсын "Frequentis AG" компанитай 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан тоног төхөөрөмж нийлүүлэх ИНЕГ/ШХО/ТББ/Б-19/19 тоот гэрээний дагуу дуун холболтын систем (VCS)-ийн үйлдвэрийн сургалтад хамруулсугай.

2. Гадаад сургалтад хамрагдсан тухай тайланг ажлын 5 хоногийн дотор удирдлагад танилцуулахыг дээрх ажилтнуудад, ажил үүрэгт нь зохицуулалт хийж, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллахыг Холбоо, навигаци, ажиглалтын алба (Г.Баттөгс)-нд тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал), Иргэний нисэхийн үндэсний төв (П.Мөнхжаргал)-д даалгасугай.

ДАРГА

С.МӨНХНАСАН



C:\My documents\TUSHAAL\2022on\gadaad surgalt.docx

17120 0408